## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/49/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.20 № 01/47

танай ____________-ны № ____________-т

ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Г.НЯМХАНД ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төмөрбулаг сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 109,480.0 мянган төгрөгийн бохирын болон ариутгалын авто машин, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 10,097.2 мянган төгрөгийн хог преслэгчийг тус тус хүлээн авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Байгууллагын төсвөөс төрийн албан хаагчдын тэмцээнд оролцсон тамирчдын буудлын зардалд 440.0 мянган төгрөг, хоолны зардалд 2,130.0 мянган төгрөг, нийт 2,570.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын эзэмшилд нийт 58 газар байгаагаас гэрээ гэрчилгээ газрын кадастрын зураггүй нийт 43 газар байна.

### *Бусад асуудлын хэсэг*

Засаг даргын Тамгын газрын дарга нь сумын Засаг даргатай 2023 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт 150 арга хэмжээний хүрээнд байгуулж, хэрэгжилтийг 98.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

6724040047

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **150,823,434.94** | **163,661,649.15** |
| **33** | **АВЛАГА** | 2,041,049.94 | 12,574,464.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 164,908.79 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 00.00 | 9,635,442.15 |
| **335** | **Бусад авлага** | 1,876,141.15 | 2,939,022.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,876,141.15 | 2,939,022.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 148,782,385.00 | 151,087,185.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 5,926,150.00 | 5,926,150.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,926,150.00 | 5,926,150.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 138,966,235.00 | 141,311,035.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 833,500.00 | 978,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,943,148.00 | 15,554,148.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 2,215,100.00 | 2,087,900.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 236,400.00 | 2,863,400.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 121,738,087.00 | 119,827,087.00 |
| 35600 | Мал амьтад | 3,890,000.00 | 3,850,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **978,700,265.92** | **1,176,626,091.29** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 978,700,265.92 | 1,176,626,091.29 |
| **392** | **Биет хөрөнгө** | 949,363,968.57 | 1,147,979,793.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 601,012,076.00 | 538,959,934.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -145,819,760.83 | -105,439,332.03 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 181,359,133.00 | 294,339,133.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -59,813,451.55 | -82,665,524.86 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 219,021,116.86 | 223,282,274.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,983,602.33 | -93,456,162.23 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32,032,340.77 | 34,886,194.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,674,329.06 | -16,585,039.99 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 330,780,254.91 | 330,780,254.91 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -164,188,616.08 | -159,068,029.82 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 65,072,500.04 | 209,074,800.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -30,433,693.16 | -26,128,707.24 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 29,336,297.35 | 28,646,297.47 |
| 39301 | Програм хангамж | 2,680,000.00 | 2,680,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -517,499.91 | -1,207,499.79 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 27,173,797.26 | 27,173,797.26 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,129,523,700.86** | **1,340,287,740.44** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **868,600.00** | **3,526,099.02** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 868,600.00 | 3,526,099.02 |
| **413** | **Өглөг** | 868,600.00 | 3,526,099.02 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 1,889,899.02 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 189,400.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 679,200.00 | 1,636,200.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 679,200.00 | 1,636,200.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,128,655,100.86** | **1,336,761,641.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,128,655,100.86 | 1,336,761,641.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 415,830,761.84 | 415,830,761.84 |
| 51101 | Өмч: - төрийн | 415,830,761.84 | 415,830,761.84 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 593,470,757.03 | 852,705,159.59 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 466,751,731.91 | 644,598,619.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 126,719,025.12 | 208,106,540.56 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 119,353,581.99 | 68,225,719.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,129,523,700.86** | **1,340,287,740.44** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **673,416,311.00** | **996,787,004.08** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **223,550,361.00** | **296,194,757.08** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 223,550,361.00 | 296,194,757.08 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 158,747,961.00 | 272,274,257.08 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө | 157,698,461.00 | 271,269,257.08 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого бараа материал | 64,802,400.00 | 23,920,500.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 49,500.00 | 5,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **449,865,950.00** | **700,592,247.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,420,150.00 | 38,489,847.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 620,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,340,800.00 | 6,520,846.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 23,459,350.00 | 31,969,001.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 421,445,800.00 | 662,102,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 421,445,800.00 | 662,102,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **543,937,285.88** | **754,117,530.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **543,937,285.88** | **754,117,530.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 505,420,148.35 | 717,782,136.76 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 259,232,485.57 | 433,020,159.38 |
| 210101 | Үндсэн цалин | 204,035,433.95 | 299,814,618.63 |
| 210102 | Нэмэгдэл | 39,262,207.62 | 103,458,863.75 |
| 210104 | Урамшуулал | 15,934,844.00 | 29,746,677.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,410,240.46 | 54,631,639.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,206,210.02 | 37,310,832.84 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,551,007.30 | 3,464,161.28 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,040,866.43 | 866,040.32 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 510,141.86 | 4,330,201.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,102,014.85 | 8,660,403.18 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,437,739.82 | 37,417,146.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,455,585.82 | 5,538,750.79 |
| 210302 | Түлш, халаалт | 26,897,154.00 | 31,878,396.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 85,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,244,145.68 | 36,228,869.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,445,199.68 | 4,055,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,930,125.00 | 24,768,366.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,305,611.00 | 3,269,903.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 274,960.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 827,150.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,461,100.00 | 3,895,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 40,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,883,550.00 | 8,217,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,883,550.00 | 8,217,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 940,000.00 | 1,813,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 940,000.00 | 1,813,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 39,686,591.00 | 22,293,424.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 38,522,788.00 | 21,131,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,000.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 247,474.00 | 131,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,829.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 687,500.00 | 656,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 140,000.00 | 320,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 109,585,395.82 | 124,160,098.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,771,210.00 | 14,410,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,814,185.82 | 109,749,498.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 38,517,137.53 | 36,335,393.43 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,508,300.00 | 2,065,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,432,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,075,500.00 | 2,065,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 22,008,837.53 | 34,270,393.43 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,008,837.53 | 34,270,393.43 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **129,479,025.12** | **242,669,473.89** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 2,760,000.00 | 34,562,933.33 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 1,905,933.33 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -2,760,000.00 | -34,562,933.33 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **126,719,025.12** | **208,106,540.56** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **450,915,450.00** | **703,473,388.15** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,049,500.00** | **1,005,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,049,500.00 | 1,005,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,049,500.00 | 1,005,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 49,500.00 | 5,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **449,865,950.00** | **702,468,388.15** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 28,420,150.00 | 40,365,988.15 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 620,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,340,800.00 | 6,520,846.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 23,459,350.00 | 33,845,142.15 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 421,445,800.00 | 662,102,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 421,445,800.00 | 662,102,400.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **442,845,450.00** | **665,161,388.15** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **442,845,450.00** | **665,161,388.15** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **402,452,171.32** | **619,190,552.57** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 259,232,485.57 | 431,192,413.42 |
| 210101 | Үндсэн цалин | 204,035,433.95 | 298,765,858.36 |
| 210102 | Нэмэгдэл | 39,262,207.62 | 102,679,878.06 |
| 210104 | Урамшуулал | 15,934,844.00 | 29,746,677.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,575,149.25 | 54,404,577.36 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,371,118.81 | 37,078,504.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,551,007.30 | 4,322,141.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,040,866.43 | 3,467,593.29 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 510,141.86 | 867,048.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,102,014.85 | 8,669,289.90 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 29,315,052.50 | 37,318,068.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,332,898.50 | 3,668,650.79 |
| 210302 | Түлш, халаалт | 26,897,154.00 | 33,649,418.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 85,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,716,671.00 | 31,908,278.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,535,000.00 | 4,950,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15,554,500.00 | 16,975,675.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,305,611.00 | 5,591,003.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 274,960.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 712,500.00 | 200,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,334,100.00 | 4,191,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,872,200.00 | 12,320,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,872,200.00 | 12,320,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 940,000.00 | 1,813,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 940,000.00 | 1,813,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,510,903.00 | 27,063,515.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,267,100.00 | 25,821,091.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 66,000.00 | 54,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 247,474.00 | 131,974.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,829.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 767,500.00 | 736,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 140,000.00 | 320,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,289,710.00 | 23,170,100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,289,710.00 | 23,170,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,393,278.68** | **45,970,835.58** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,508,300.00 | 2,065,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,432,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,075,500.00 | 2,065,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 23,884,978.68 | 43,905,835.58 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 23,884,978.68 | 43,905,835.58 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,070,000.00** | **38,312,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,070,000.00** | **38,312,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,070,000.00** | **38,312,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,070,000.00 | 38,312,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 8,070,000.00 | 38,312,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-8,070,000.00** | **-38,312,000.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 415,830,761.84 | 122,409,477.99 | 80,264,248.88 | 618,504,488.71 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 78,819,871.20 | 78,819,871.20 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **415,830,761.84** | **122,409,477.99** | **159,084,120.08** | 697,324,359.91 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 307,667,611.83 | 307,667,611.83 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **415,830,761.84** | **119,353,581.99** | **593,470,757.03** | 1,128,655,100.86 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **415,830,761.84** | **119,353,581.99** | **593,470,757.03** | 1,128,655,100.86 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 51,127,862.00 | 51,127,862.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **415,830,761.84** | **119,353,581.99** | **644,598,619.03** | 1,179,782,962.86 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -51,127,862.00 | 00.00 | -51,127,862.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 208,106,540.56 | 208,106,540.56 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **415,830,761.84** | **68,225,719.99** | **852,705,159.59** | 1,336,761,641.42 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 663,102,400.00 | 628,837,006.57 | 34,265,393.43 | 94.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 663,102,400.00 | 628,837,006.57 | 34,265,393.43 | 94.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 661,777,400.00 | 627,512,006.57 | 34,265,393.43 | 94.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 444,912,800.00 | 431,192,413.42 | 13,720,386.58 | 96.9 |
| 210101 | Үндсэн цалин | 299,034,000.00 | 298,765,858.36 | 268,141.64 | 99.9 |
| 210102 | Нэмэгдэл | 104,007,600.00 | 102,679,878.06 | 1,327,721.94 | 98.7 |
| 210104 | Урамшуулал | 41,871,200.00 | 29,746,677.00 | 12,124,523.00 | 71.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,999,100.00 | 54,404,577.36 | 1,594,522.64 | 97.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,637,800.00 | 37,078,504.13 | 559,295.87 | 98.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,077,300.00 | 4,322,141.67 | 755,158.33 | 85.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,542,300.00 | 3,467,593.29 | 74,706.71 | 97.9 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 885,700.00 | 867,048.37 | 18,651.63 | 97.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,856,000.00 | 8,669,289.90 | 186,710.10 | 97.9 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 39,180,000.00 | 37,318,068.79 | 1,861,931.21 | 95.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,080,000.00 | 3,668,650.79 | 411,349.21 | 89.9 |
| 210302 | Түлш, халаалт | 34,500,000.00 | 33,649,418.00 | 850,582.00 | 97.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 600,000.00 | 00.00 | 600,000.00 | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,170,000.00 | 28,796,878.00 | 3,373,122.00 | 89.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,900,000.00 | 4,900,000.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,440,000.00 | 14,414,275.00 | 25,725.00 | 99.8 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,000,000.00 | 5,591,003.00 | 408,997.00 | 93.2 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 00.00 | 500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,750,000.00 | 200,000.00 | 1,550,000.00 | 11.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,580,000.00 | 3,691,600.00 | 888,400.00 | 80.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 47,184,100.00 | 40,998,000.00 | 6,186,100.00 | 86.9 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,000,000.00 | 19,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210602 | Тавилга | 1,680,000.00 | 1,680,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 26,504,100.00 | 20,318,000.00 | 6,186,100.00 | 76.7 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,400,000.00 | 1,813,600.00 | 586,400.00 | 75.6 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,400,000.00 | 1,813,600.00 | 586,400.00 | 75.6 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,031,400.00 | 26,553,169.00 | 2,478,231.00 | 91.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 26,732,200.00 | 25,310,745.00 | 1,421,455.00 | 94.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600,000.00 | 54,450.00 | 545,550.00 | 9.1 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 131,974.00 | 118,026.00 | 52.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 129,200.00 | 00.00 | 129,200.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,000,000.00 | 736,000.00 | 264,000.00 | 73.6 |
| 210807 | Газрын төлбөр | 320,000.00 | 320,000.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10900000.00 | 6435300.00 | 4,464,700.00 | 59.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,900,000.00 | 6,435,300.00 | 4,464,700.00 | 59.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1325000.00 | 1325000.00 | 0.00 | 100.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,325,000.00 | 1,325,000.00 | 0.00 | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,325,000.00 | 1,325,000.00 | 0.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 663,102,400.00 | 628,837,006.57 | 34,265,393.43 | 94.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 585,529,400.00 | 627,832,006.57 | -42,302,606.57 | 107.2 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 585,529,400.00 | 627,832,006.57 | -42,302,606.57 | 107.2 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 77,573,000.00 | 1,005,000.00 | 76,568,000.00 | 1.3 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 5,000.00 | -5,000.00 | #DIV/0! |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 1,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 76,573,000.00 | 00.00 | 76,573,000.00 | - |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 26.00 | 26.00 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 08.00 | 08.00 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12.00 | 12.00 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 02.00 | 02.00 | 0.00 | 100.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 04.00 | 04.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **40,365,988.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **40,365,988.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 29,990,546.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,111,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 50,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,561,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,322,000.00 |
| 210602 | Тавилга | 2,090,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,232,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,822,346.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,822,346.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16734800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,734,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 740000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 740,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 740,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **9,635,442.15** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 9,635,442.15 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 40365988.15 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,365,988.15 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,520,846.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 33,845,142.15 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 254,350.8 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залруулсан. Үүнд:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнэ шинэчлэн тогтоосон шийдвэр гарсан байхад хөрөнгүүдийг данснаас хасаж үнэ тогтоож орлогод аваагүй 254,350.8 мянган төгрөгийн алдаа илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5."бүх орлого" гэсэн заалттай нийцээгүй тул аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 47,702.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 47,702.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж , 2,570.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон.

### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын эзэмшилд байгаа газрын талаар судалгаа авч горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрсэн. Үүнд:

Байгууллагын төсвөөс төрийн албан хаагчдын тэмцээнд оролцсон тамирчдын буудлын зардалд 440.0 мянган төгрөг, хоолны зардалд 2,130.0 мянган төгрөг, нийт 2,570.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3."үр ашигтай байх", "15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Татвар нийгмийн даатгалын шимтгэлийг тооцохдоо зөрүүтэй тооцсоноос байгууллагаас авах авлага 2,488.0 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 1,185.2 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон өглөг 1,889.9 мянган төгрөг нийт 3,075.1 мянган төгрөгийн өр төлбөрийг тус тус үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт болон "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

**2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын санхүүгийн тайланг 2024.01.25-ны өдөр гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тодруулга толилуулга бичээгүй тайлан ирүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгэр зүйлийн 54.4.5."санхүүгийн тайлангийн тодруулга", 54.5."Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэсэн заалтууд болон иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулж, иж бүрэн бэлтгэж байх.

**3. Байгууллагын дансанд бүртгэлтэй газартай холбоотой асуудал.**

Илрүүлэлт: Байгууллагын эзэмшилд нийт 58 газар байгаагаас гэрээ гэрчилгээ газрын кадастрын зураггүй нийт 43 газар байна. Энэ нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 "Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ.", 27.2. "Газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгоно.", 27.3. "Нэгж талбар бүр эрхийн гэрчилгээтэй байна." 34.10. "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ нь тухайн газар дээрх тэдгээрийн үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшил газруудыг гэрээ, гэрчилгээтэй болгож, кадастрын зураг хийлгэх.

**4. Байгууллагын дансанд бүртгэлтэй газрын үнэлгээтэй холбоотой асуудал.**

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 48 газрын нэгж үнийг нь 51.01 төгрөгөөр бүртгэж орлогод авсан байна. Энэ нь засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын "бусад сумын төв (хот, тосгон, бусад суурины газар)-ийн газрын үнэлгээний зэрэглэл, 1 га газрын суурь үнэлгээ" 2 дугаар хавсралттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын эзэмшил газруудын үнийг шинэчлэн тогтоох.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бүртгэл тайлагналын алдаа | 2 | 254,350.8 | 1 | 149,300.7 | 1 | 105,050.1 | 2 | 254,350.8 |
| **Дүн** | **2** | **254,350.8** | **1** | **149,300.7** | **1** | **105,050.1** | **2** | **254,350.8** |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой | 3 | 8,133.1 | 1 | 2,570.0 | | | 2 | 5,563.1 |
| **Дүн** | **3** | **8,133.1** | **1** | **2,570.0** | | | **2** | **5,563.1** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын газрын үнэлгээ, бичиг баримттай холбоотой | 2 | | | | | | 2 | |
| **Дүн** | **2** | | | | | | **2** | |